



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/141/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн Аудитор: Ц.Болормаа Утас: 99163087, Цахим хаяг: shurtkhaikhaniikhishigaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.1Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2025.01.30 № УВА/МН/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050109

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>304,670,512.37</u>	<u>235,488,507.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,714,620.42	10,676,731.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,714,620.42	10,676,731.75
3121	Төгрөг	18,714,620.42	10,676,731.75
31211	Төрийн сангийн харилцах	18,714,620.42	10,676,731.75
33	АВЛАГА	110,133,873.91	12,603,187.47
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	110,031,574.01	12,603,187.47
335	Бусад авлага	102,299.90	00.00
3351	Байгууллагаас авах авлага	102,299.90	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	175,822,018.04	212,208,588.04
351	Түүхий эд материал	42,248,293.90	73,964,223.90
35130	Эм боох материал	42,248,293.90	73,964,223.90
354	Хангамжийн материал	133,573,724.14	138,244,364.14
35410	Бичиг хэргийн материал	7,263,350.00	7,049,700.00
35420	Аж ахуйн материал	91,914,972.74	98,748,446.74
35430	Сэлбэг хэрэгсэл	13,858,000.00	8,773,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,200,000.00	00.00
35460	Хүнсний материал	18,602,401.40	22,938,217.40
35470	Бусад хангамжийн материал	735,000.00	735,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,004,152,184.54</u>	<u>918,744,337.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,004,152,184.54	918,744,337.53
392	Биет хөрөнгө	995,164,184.54	909,756,337.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,046,781,775.82	1,046,781,775.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	-364,824,951.98	-392,803,826.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,858,571.43	150,578,571.43
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,425,595.10	-83,261,309.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,419,789.56	114,221,815.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-73,309,793.69	-81,606,003.30
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,223,214.80	47,262,702.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,926,957.08	-29,968,759.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	213,672,195.60	241,337,805.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	-65,386,064.82	-102,868,435.32
39217	Ном	82,000.00	82,000.00
393	Биет бус хөрөнгө	8,988,000.00	8,988,000.00
39301	Програм хангамж	330,000.00	330,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-330,000.00	-330,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,988,000.00	8,988,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,308,822,696.91</u>	<u>1,154,232,844.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,497,923.00</u>	<u>16,197,750.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,497,923.00	16,197,750.00
413	Өглөг	6,497,923.00	16,197,750.00
4136	Бусад өглөг	6,497,923.00	16,197,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,307,923.00	11,437,750.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,190,000.00	4,760,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,302,324,773.91</u>	<u>1,138,035,094.79</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,302,324,773.91	1,138,035,094.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	278,814,812.00	278,814,812.00
51101	Өмч: - төрийн	278,814,812.00	278,814,812.00
512	Хуримтлагдсан үр дүн	587,080,140.17	422,862,292.35
51210	Өмнөх үеийн үр дүн	587,080,140.17	587,151,971.47
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-164,289,679.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	436,429,821.74	436,357,990.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,308,822,696.91</u>	<u>1,154,232,844.79</u>

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	528,756,495.82	1,080,407,640.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,874,291.40	29,402,938.10
120	Нийтлэг татварын бус орлого	7,874,291.40	29,402,938.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	15,259,319.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	15,259,319.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	520,882,204.42	1,051,004,702.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,264,000.00	32,268,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,264,000.00	32,268,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	495,618,204.42	1,018,736,102.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	495,618,204.42	1,018,736,102.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	483,753,564.57	1,244,697,319.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,753,564.57	1,244,697,319.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,753,564.57	1,243,987,318.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,553,407.96	847,384,284.74
210101	Үндсэн цалин	184,870,246.56	452,418,530.21
210102	Нэмэгдэл	99,472,651.40	294,029,955.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,704,000.00	31,556,838.77
210104	Урамшуулал	17,506,510.00	69,378,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,579,643.55	105,899,197.37
210201	Тэтгэврийн даатгал	26,010,468.27	70,975,035.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,097,489.18	8,710,466.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,748,915.82	4,488,146.57
210204	Ажилгүйдлийн даатгал	1,569,997.25	4,345,130.50
210205	Эрүүл мэндийн даатгал	6,152,773.03	17,380,419.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,472,793.52	41,986,349.57
210301	Гэрэл, цахилгаан	2,212,130.52	6,538,349.57
210302	Түлш, халаалт	19,260,663.00	35,448,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,543,813.10	58,319,056.00
210401	Бичиг хэрэг	1,926,000.00	2,671,950.00
210402	Тээвэр, шатахуун	17,609,960.00	25,875,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	1,188,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	462,000.00	735,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,050,853.10	4,900,850.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	22,948,076.00
2105	Нормативт зардал	36,780,476.80	61,611,799.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,266,119.80	46,604,495.00
210502	Хоол, хүнс	14,514,357.00	15,007,304.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	556,000.00
210604	Урсгал засвар	00.00	556,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,696,000.00	10,260,000.00
210702	Дотоод албан томилолт	2,696,000.00	10,260,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,807,480.00	1,613,876.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,600.00	141,000.00

**Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	248,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,000.00	240,496.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	88,000.00	00.00
210807	Газрын төлбөр	89,880.00	89,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,319,949.64	116,356,756.11
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,319,949.64	116,356,756.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	710,000.43
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	710,000.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	710,000.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,002,931.25	-164,289,679.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	45,002,931.25	-164,289,679.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	972,812,846.36	1,163,692,407.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,497,440.00	15,259,319.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,497,440.00	15,259,319.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,497,440.00	15,259,319.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,497,440.00	00.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	15,259,319.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	970,315,406.36	1,148,433,088.54
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,977,200.00	32,268,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,977,200.00	32,268,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	927,338,206.36	1,116,164,488.54
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	927,338,206.36	1,116,164,488.54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	970,232,168.23	1,148,172,296.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	970,232,168.23	1,148,172,296.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,929,668.13	1,147,462,295.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,386,392.47	847,281,984.84
210101	Үндсэн цалин	416,066,425.58	452,316,230.31
210102	Нэмэгдэл	204,361,628.22	294,029,955.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,312,000.00	31,556,838.77
210104	Урамшуулал	42,646,338.67	69,378,960.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,134,295.76	105,899,197.37
210201	Тэтгэврийн даатгал	57,594,609.59	70,975,035.26
210202	Тэтгэмжийн даатгал	6,865,322.27	8,710,466.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,687,851.44	4,488,146.57
210204	Ажилгүйдлийн даатгал	3,498,519.53	4,345,130.50
210205	Эрүүл мэндийн даатгал	13,487,992.93	17,380,419.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,477,199.90	30,018,599.57
210301	Гэрэл, цахилгаан	5,456,947.90	6,538,349.57
210302	Түлш, халаалт	35,020,252.00	23,480,250.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,054,900.00	43,387,880.00
210401	Бичиг хэрэг	2,795,250.00	4,345,300.00
210402	Тээвэр, шатахуун	34,490,550.00	25,875,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,000.00	1,188,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	615,000.00	1,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,966,100.00	10,379,400.00
2105	Нормативт зардал	109,542,135.00	105,067,758.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,913,055.00	76,766,638.00
210502	Хоол, хүнс	24,189,080.00	19,343,120.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,440,000.00	8,958,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,260,700.00	7,503,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,620,000.00	2,277,000.00
210604	Урсгал засвар	5,640,700.00	5,226,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,056,000.00	6,690,000.00
210702	Дотоод албан томилолт	9,056,000.00	6,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,170,045.00	1,613,876.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,107,600.00	141,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	248,100.00

**Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,565.00	240,496.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	426,000.00	00.00
210807	Газрын төлбөр	89,880.00	89,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	848,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	848,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	302,500.10	710,000.43
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	302,500.10	710,000.43
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	302,500.10	710,000.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,580,678.13	15,520,111.33
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,850,000.00	23,558,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,850,000.00	23,558,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,850,000.00	23,558,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,850,000.00	23,558,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,850,000.00	-23,558,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-9,269,321.87	-8,037,888.67
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,983,942.29	18,714,620.42
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,714,620.42	10,676,731.75

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	269,826,812.00	343,439,188.91	-297,790,879.91	315,475,121.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	20,728.85	20,728.85
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	269,826,812.00	343,439,188.91	-297,770,151.06	315,495,849.85
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	8,988,000.00	00.00	33,370,869.44	42,358,869.44
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	278,814,812.00	436,429,821.74	587,080,140.17	1,302,324,773.91
9	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	278,814,812.00	436,429,821.74	587,080,140.17	1,302,324,773.91
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	71,831.30	71,831.30
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	278,814,812.00	436,429,821.74	587,151,971.47	1,302,396,605.21
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-71,831.30	00.00	-71,831.30
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
16	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-164,289,679.12	-164,289,679.12
17	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	278,814,812.00	436,357,990.44	422,862,292.35	1,138,035,094.79

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,181,628,000.00	1,139,461,696.21	42,166,303.79	96.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,628,000.00	1,139,461,696.21	42,166,303.79	96.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,176,503,000.00	1,139,461,696.21	37,041,303.79	96.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	857,770,200.00	847,281,984.84	10,488,215.16	98.78
210101	Үндсэн цалин	541,754,600.00	452,316,230.31	89,438,369.69	83.49
210102	Нэмэгдэл	198,258,700.00	294,029,955.76	(95,771,255.76)	148.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,855,200.00	31,556,838.77	13,298,361.23	70.35
210104	Урамшуулал	72,901,700.00	69,378,960.00	3,522,740.00	95.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,601,500.00	105,899,197.37	702,302.63	99.34
210201	Тэтгэврийн даатгал	71,705,800.00	70,975,035.26	730,764.74	98.98
210202	Тэтгэмжийн даатгал	8,723,900.00	8,710,466.01	13,433.99	99.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,362,000.00	4,488,146.57	(126,146.57)	102.89
210204	Ажилгүйдлийн даатгал	4,362,000.00	4,345,130.50	16,869.50	99.61
210205	Эрүүл мэндийн даатгал	17,447,800.00	17,380,419.03	67,380.97	99.61
2104	Хангамж, бараа материалын зардал	59,151,900.00	43,387,880.00	15,764,020.00	73.35
210401	Бичиг хэрэг	5,118,800.00	4,345,300.00	773,500.00	84.89
210402	Тээвэр, шатахуун	39,094,300.00	25,875,180.00	13,219,120.00	66.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,100.00	1,188,000.00	398,100.00	74.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,852,700.00	1,600,000.00	252,700.00	86.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,500,000.00	10,379,400.00	1,120,600.00	90.26
2105	Нормативт зардал	109,069,500.00	105,067,758.00	4,001,742.00	96.33
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,774,900.00	76,766,638.00	(4,991,738.00)	106.95
210502	Хоол, хүнс	26,794,600.00	19,343,120.00	7,451,480.00	72.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,500,000.00	8,958,000.00	1,542,000.00	85.31

**Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,765,000.00	29,521,000.00	244,000.00	99.18
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,010,000.00	25,835,000.00	175,000.00	99.33
210604	Урсгал засвар	3,755,000.00	3,686,000.00	69,000.00	98.16
2107	Томилолт, зочны зардал	10,000,000.00	6,690,000.00	3,310,000.00	66.90
210702	Дотоод албан томилолт	10,000,000.00	6,690,000.00	3,310,000.00	66.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,707,900.00	1,613,876.00	2,094,024.00	43.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,050,000.00	141,000.00	909,000.00	13.43
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	301,600.00	248,100.00	53,500.00	82.26
210804	Тээврийн хэрэгслийн татвар	497,000.00	240,496.00	256,504.00	48.39
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	320,000.00	88,000.00	232,000.00	27.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	637,900.00	-	637,900.00	-
210807	Газрын төлбөр	95,000.00	89,880.00	5,120.00	94.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	437,000.00	-	437,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	437,000.00	-	437,000.00	-
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,187,393,800.00	1,131,423,807.54	55,969,992.46	95.29
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,187,393,800.00	1,116,164,488.54	71,229,311.46	94.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	18,714,620.42	(18,714,620.42)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,676,731.75	(10,676,731.75)	-

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /орон нутгийн төсөв/

10	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,268,600.00	31,558,599.57	710,000.43	97.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,268,600.00	31,558,599.57	710,000.43	97.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,268,600.00	31,558,599.57	710,000.43	97.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,018,600.00	30,018,599.57	0.43	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,680,100.00	6,538,349.57	1,141,750.43	85.13
210302	Түлш, халаалт	22,020,100.00	23,480,250.00	(1,460,150.00)	106.63
210303	Цэвэр, бохир ус	318,400.00	-	318,400.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	1,540,000.00	710,000.00	68.44
210604	Урсгал засвар	2,250,000.00	1,540,000.00	710,000.00	68.44
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,268,600.00	31,558,599.57	710,000.0	97.80
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,268,600.00	31,558,599.57	710,000.0	97.80
320001	Орон нутгийн төсвөөс	32,268,600.00	31,558,599.57	710,000.0	97.80

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хуульд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154,589.9 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,714.6	10,676.7	-8,037.9
Авлага	110,133.9	12,603.2	-97,530.7
Урьдчилгаа			-
Бараа материал	175,822.0	212,208.6	36,386.6
Үндсэн хөрөнгө	1,004,152.2	918,744.3	-85,407.9
Нийт хөрөнгө	1,308,822.7	1,154,232.8	-154,589.9
Өр төлбөр	6,497.9	16,197.8	9,699.9
Засгийн газрын хувь оролцоо	1,302,324.7	1,138,035.1	-164,289.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,308,822.7	1,154,232.8	-154,589.9

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,676.7 мянган төгрөг болж 8,037.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн урьд үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 12,603.2 мянган төгрөг болж, 97,530.7 мянган төгрөгөөр буурсан нь төлбөртэй үйлчилгээний авлага 125,003.1 мянган төгрөгөөр, байгууллагаас авах авлага 102.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 212,208.6 мянган төгрөг болж 54,386.6 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал 31,715.9 мянган төгрөг, аж ахуйн материал 6,833.5 мянган төгрөг, хүнсний материал 4,335.8 мянган төгрөгөөр өсч, бичиг хэргийн материал 213.7 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 5,085.0 мянган төгрөг, түлш шатах тослох материал 1,200.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 918,744.3 мянган төгрөг болж, 85,407.9 мянган төгрөгөөр буурсан нь авто тээврийн хэрэгсэл 5,280.0 мянга, тоног төхөөрөмж 4,198.0 мянга, тавилга эд хогшил 960.5 мянган төгрөгөөр буурч, бусад үндсэн хөрөнгө 27,665.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн, тайлант хугацааны үндсэн хөрөнгийн элэгдэл 102,635.0 мянган төгрөг гарсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 16,197.7 мянган төгрөг болж, 9,699.8 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагад төлөх өглөг 6,129.8 мянга, хувь хүмүүст төлөх өглөг 3,570.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,138,035.1 мянган төгрөг болж 164,289.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,420,634.6 мянга, орон нутгийн төсвөөс 44,515.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,465,150.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд улсын төсвөөс 1,181,628.0 мянга, орон нутгийн төсвөөс 32,268.6 мянга, нийт 1,213,896.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 67 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,116,164.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 31,558.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,139,461.7 мянга, орон нутгийн төсвөөс 31,558.6 мянган төгрөг олгож нийт 1,171,020.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,171,020.3 мянган төгрөг буюу 102 хувьтай байгаа нь өмнөх оны санхүүжилтээс зарцуулсантай холбоотой байна.

**Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл/Улсын төсөө/

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	780,468.10	780,468.10	0.00	100%
2	81603	үндсэн мэргэжлийн тусламж үйлч	285,703.30	258,139.30	27,564.00	90%
3	83603	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан	115,456.60	100,854.30	14,602.30	87%
		ДҮН	1,181,628.0	1,139,461.70	42,166.30	96%

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл / Орон нутгийн төсөө/

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	32,268.60	31,558.60	710.00	98%
		ДҮН	32,268.60	31,558.60	710.00	98%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл, тайлагнал	0.0	0.0	Санхүүгийн программийг 2011 онд 55.0 мянга, няравын программийг 2016 онд 275.0 мянган төгрөгийн программ хангамж дансанд бүртгэлтэй байна.
2	Унаа хоолны хөнгөлөлт, зардлын тариф	44,855.2	31,556.8	Дотоод журамд заасны дагуу нэг хүнд 1 өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээнд зарцуулсан зардал	0.0	0.0	Тайлант онд гадаад томилолтод зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал	0.0	0.0	Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй байна.

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан				
6	Орон тооны цомхотгол	0.0	0.0	Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна.
7	Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл	0.0	0.0	Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудад төлбөр төлөөгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 150,132.7 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хооронд Шүрт хайрханы хишиг аудит ХХК-ийн аудитор Ц.Болормаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нямбуу, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Шүрт хайрханы хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны санхүүгийн үр

дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,244,697.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,447.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг төлөвлөлтийн 80.0 хувиар буюу 9,957.6 мянган төгрөгөөр гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өлгий сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 44 мэдээллээс хугацаандаа оруулсан 44 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

ДД	Аудитын нэр	Төрөл	Зөрчлийн утга	Шийдвэр	Өгсөн	Хэрэгжилт	Үлдэгдэл
1	Өлгий сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан	Санхүү	Увс аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 07-р сарын 03-ны өдрийн Б/40 дугаартай тушаалаар 2023 оны санхүүгийн тайлангийн дүгнэлтээр "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан гэж дарга, нягтлан бодогч нарт 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож, нийт 1,467.0 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.	Зөвлөмж	1,467.0	1467.0	-
	дүн				1,467.0	1,467.00	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 469.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

5.1. Төлбөрийн акт

1. Эрүүл мэндийн төв нь сувилагч Ч.Сүрэнхорлоод ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 469.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.2-т "Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгоно", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Эрүүл мэндийн төв нь сувилагч Ч.Сүрэнхорлоод ээлжийн амралтын цалин болон тухайн сарын цалинг давхардуулан тооцож 469.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.	1	469.6	1	469.6									
Дүн	1	469.6	1	469.6									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж						
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Дүн													
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Дүн													
Нийт дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР

/С.БАТСАЙХАН/

2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 01/03/В.2715686
УБА-2026/МН/НА-СТА-ТМЗ

Улаангом

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өлгий сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн сувилагч Ч.Сүрэнхорлоод ээлжийн амралтын мөнгө болон цалинг давхардуулан тооцож 469,669 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон цалин 469,669 (дөрвөн зуун жаран есөн мянга зургаан зуун жаран есөн) төгрөгийг Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй Өлгий сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Сэржмядаг, нягтлан бодогч Б.Содгэрэл нараар төлүүлж, Төрийн сан дахь МХГ-ын орлогын 1000150000982 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Өлгий сумын засаг дарга Б.Бархасбадь-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТОССОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТСУУРЬ
М.БАТ-АМГАЛАН

“ШҮРТ ХАЙРХАНЫ ХИШИГ АУДИТ” ХХК-ийн
АУДИТОР

С.БАТСАЙХАН